

Гарчиг

1.	ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.2.	Төслийн товч танилцуулга	3
1.3.	Уурхайн календарчилсан төлөвлөгөө	4
1.4.	Уурхайн ажиллах горим	4
1.5.	Уулын ажлын төлөвлөгөө	5
1.6.	Уурхайн үндсэн техник, тоног- төхөөрөмжийн иж бүрдэл	5
1.7.	Баяжуулах технологи	6
1.8.	Ус ашиглалт	8
1.9.	Цахилгаан хангамж, ашиглалт	11
1.10.	Дулаан хангамж	11
1.11.	Химийн бодисын хэрэглээ	11
1.12.	Хог хаягдал	11
1.13.	Дэд бүтэц	13
2.	БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	15
2.1.	Цаг уур, уур амьсгал	15
2.2.	Гадаргын ус	15
2.3.	Хөрсний төлөв байдал	16
2.4.	Ургамлан бүрхэвч	18
2.5.	Бүрэгхангай сумын нийгэм эдийн засгийн судалгаа	20
3.	ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	21
4.	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	23
5.	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	24
5.1.	Ордын ашиглалтын үед сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	24
5.2.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	28
5.3.	Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө	28
5.4.	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	29
5.5.	Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	29
5.6.	Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	29
5.7.	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	30
5.8.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	30
6.	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	32
6.1.	БОМТ-ний хэрэгжилтийн талаар нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө	34

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Төслийн талбайн координат цэг	3
Хүснэгт 2.	Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө	4
Хүснэгт 3.	Уурхайн ажиллах горим, хүчин чадлын үзүүлэлт	5
Хүснэгт 4.	Ил уурхайн техник, тоног-төхөөрөмжийн иж бүрдэл	5
Хүснэгт 5.	Баяжуулах хэсгийн ажиллах горим	7
Хүснэгт 6.	Баяжуулах хэсгийн хүчин чадал	7
Хүснэгт 7.	Технологийн усан сангийн багтаамж	8
Хүснэгт 8.	Уурхайн ажилчдын унд ахуйн ус хэрэглээний тооцоо	8
Хүснэгт 9.	Баяжуулах үйлдвэрийн усны хэрэглээ	9
Хүснэгт 10.	Нөхөн сэргээлтэд зарцуулах усны тооцоо	10
Хүснэгт 11.	Зам талбайг услах усны тооцоо	10
Хүснэгт 12.	Төслийн үйл ажиллагааны үед ашиглах усны тооцоо	10
Хүснэгт 13.	Туул голоос авч ашиглаж болох усны хэмжээ	11
Хүснэгт 14.	Төслийн үйл ажиллагаанаас гарах аюултай хог хаягдал	11
Хүснэгт 15.	Ургамлын бичиглэл-1 (ургамалжилт)	18
Хүснэгт 16.	Ургамлын бичиглэл-2 (ургамалжилт)	19
Хүснэгт 17.	Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим	21
Хүснэгт 18.	Төслийн байршилтай холбоотой болзошгүй нөлөөлөл	22

Хүснэгт 19. Ордын ашиглалтын үед сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	24
Хүснэгт 20. Нөхөн сэргээлтийн зардал.....	28
Хүснэгт 21. Хаалтын нөхөн сэргээлт.....	28
Хүснэгт 22. 2025 онд тарих модны хэмжээ, зардал.....	28
Хүснэгт 23. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө.....	29
Хүснэгт 24. Төслийн явцад хэрэгжүүлэх түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө.....	29
Хүснэгт 25. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	30
Хүснэгт 26. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	30
Хүснэгт 27. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	33
Хүснэгт 28. БОМТ тайлагнах төлөвлөгөө	34
Хүснэгт 29. БОМТ-ний нийт зардал.....	35

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршил	3
Зураг 2. Ил уурхайн техник, тоног-төхөөрөмжүүдийн иж бүрдэл	6
Зураг 3. Ордын алт агуулсан элсийг угаан баяжуулах технологийн бүдүүвч.....	6
Зураг 4. Худгийн байршил.....	9
Зураг 5. Ажилчдын байр	13
Зураг 6. Уурхайн оффис.....	13
Зураг 7. Гал тогоо.....	14
Зураг 8. Угаалгын газар.....	14
Зураг 9. Төслийн талбайн орчны хөрсний тархалтын зураглал.....	17
Зураг 10. Хөрсний зүсэлт-1	18
Зураг 11. Ширэг улалж-дэрст бүлгэмдэл	19
Зураг 12. Хазаар өвс-Хялганат бүлгэмдэл.....	19
Зураг 13. Төслийн талбайн ургамлын хэв шинж	20

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч: “Гэрэлт шинэчлэл” ХХК

УБД: 9011071145, РД: 5046483

Төслийн нэр: “Туулын талбайн өмнөд хэсгийн үүсмэл орд болон Бүрэг нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах” төсөл

Төслийн зорилго: Уул уурхайн үйлдвэрлэл хөгжүүлж алт олборлох

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-021324

Төслийн талбайн байршил: MV-021324 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай нь Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг Бүрэг хэмээх газар. Улаанбаатар хотоос баруун хойш 210-250 км-т, Бүрэгхангай сумаас 40 км-т тус тус байрлана.

Хүснэгт 1. Төслийн талбайн координат цэг

№	Уртраг	Өргөрөг
1	104° 20' 04.93"	48° 14' 40.82"
2	104° 20' 13.94"	48° 14' 49.83"
3	104° 20' 13.85"	48° 14' 56.88"
4	104° 20' 21.03"	48° 14' 56.92"
5	104° 20' 23.51"	48° 14' 59.04"
6	104° 20' 23.47"	48° 14' 02.12"
7	104° 20' 26.25"	48° 15' 02.12"
8	104° 20' 40.93"	48° 15' 16.82"
9	104° 20' 40.93"	48° 14' 40.82"



Зураг 1. Төслийн талбайн байршил

1.2. Төслийн товч танилцуулга

“Гэрэлт шинэчлэл” ХХК нь Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших Бүрэг нэртэй газар нь MV-021324 дугаартай 43.1 га газар бүхий ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй болно. Уг орд газар нь Улаанбаатар хотоос баруун хойд зүгт 210-250 км, Бүрэгхангай сумын төвөөс зүүн зүгт 40 км-т байрладаг.

2017 онд 529.6 тууш метр цохилтот өрөмдлөгийн ажил, 1600 м³ бөөний дээжлэлт, 76.2

тууш метр шурф нэвтрэлтийн ажлуудыг хийж гүйцэтгэн ил аргаар олборлох (В) зэрэглэлээр металл 11,18 кг, элс 33.81 мян.м³, бага оврын драгын аргаар (С) зэрэглэлээр металл 16.92 кг, 210.95 мян.м³ элс, нийт 28.11 кг металл бүхий үүсмэл ордыг тогтоон ЭБМЗ-р хэлэлцүүлэн батлуулж ашиглалтад бэлдсэн.

2018 онд “Туулын талбайн өмнөд хэсэг”-ийн 1998-1999 онуудад ил аргаар олборлолт явуулсан блок (С1-20) хэсэглэлд уулын ашиглалтын тайланг үндэслэн ашиглалтын үеийн үлдэгдэл (целик) нөөцийг ашиглалтын үеийн өгөгдлөөр тооцон нийт 1.60 мян.м² талбайд 6.15 мян.м³ хөрс, 1327 мг/м³ дундаж агуулга бүхий 3.24 мян.м³ элстэй нөөцийн (В) зэрэглэлээр химийн цэврээр 4.3 кг алтны үлдэгдэл байгааг тогтоосон байна.

Уурхай нь жилд дунджаар 120.0 мян.м³ алт агуулсан элс олборлох хүчин чадлаар ажиллахаар төлөвлөсөн ба ийм хүчин чадлаараа цаашид ажиллахад ордын үйлдвэрлэлийн нөөцийг 2 жилийн хугацаанд ашиглахаар ТЭЗҮ-д тусгаж тооцсон байна. Иймээс ашиглалтын 2 жилийн хугацаа болон нөхөн сэргээлт, техник тоног төхөөрөмжийг зөөвөрлөх хугацааг тооцон БОМТ-г 3 жилээр тооцоо.

Уг төслийн хүрээнд 48 хүний ажлын байр бий болно. Төслийн хэмжээнд жилд 623.8 мян.м³ ус ашиглах бөгөөд усны эх үүсвэр нь тухайн орон нутгаас зөөврөөр хангана.

1.3. Уурхайн календарьчилсан төлөвлөгөө

“Туулын талбайн өмнөд хэсэг (ХШ-967-971) үүсмэл орд болон Бүрэг” нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах уулын ажлын календарьчилсан төлөвлөгөөг төсөл захиалагчийн ажлын даалгаварт тусгасан хүчин чадалд үндэслэн боловсруулсан байна.

Жилд 120.0 мян.м³ алт агуулсан элс олборлох хүчин чадлаар тооцоход уг ордыг ашиглах хугацаа нь 2 жил болж байна. Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөөнд ашиглалтын хугацаан дахь жил бүрд хийгдэх шимт хөрс хуулалт, хөрс хуулалт болон алт агуулсан элс олборлолтын ажлын хэмжээг дэлгэрэнгүй тооцоолон дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 2. Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө

№	Үндсэн үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Ашиглалтын жилүүд						Нийт
			1-р жил			2-р жил			
			3-р улирал (6-8 сар)	4-р улирал (9-10 сар)	1-р жилд нийт	2-р улирал (5-6 сар)	3-р улирал (7-9 сар)	2-р жилд нийт	
1	Уулын цул	мян.м3	140.24	100.18	240.41	100.18	140.71	240.89	481.30
2	Хөрс хуулалт	мян.м3	70.24	50.18	120.42	50.18	70.48	120.65	241.07
2.1	Үүнээс: шимт хөрс хуулалт	мян.м3	2.66	1.90	4.55	1.90	2.66	4.56	9.11
2.2	Үүнээс: үндсэн хөрс хуулалт	мян.м3	67.58	48.28	115.86	48.28	67.82	116.09	231.96
3	Элс олборлолт	мян.м3	70.00	50.00	120.00	50.00	70.23	120.23	240.23
4	Дундаж агуулга	гр/м3	0.220	0.082	0.163	0.082	0.098	0.092	0.127
5	Алт (Шлихээр)	кг	15.40	4.11	19.50	4.11	6.91	11.01	30.52
6	Алт (Хими цэврээр)	кг	13.55	3.61	17.16	3.61	6.08	9.69	26.85
7	Хөрс хуулалтын дундаж итгэлцүүр	м3/м3	0.97	0.97	-	0.97	0.97	-	-
8	Олборлолтод өртөх талбай	мян.м2	13.28	9.48	22.76	9.48	13.32	22.81	45.57

1.4. Уурхайн ажиллах горим

Ил уурхайн уулын ажил нь улирлын чанартай явагдах бөгөөд ашиглалтын эхний жилд 1/ХII-ээс 15/VI-н хүртэл өвлийн улирлын сул зогсолт, үндсэн олборлолтын үйл ажиллагаа 1/VII-оос 31/XI-ийг хүртэл явагдах бөгөөд 1 дэх жилд нийтдээ 5 сар ажиллах юм. Ашиглалтын 2 дахь жилд 1/Х-ээс 15/IV-н хүртэл өвлийн улирлын сул зогсолт, үндсэн олборлолтын үйл ажиллагаа 1/V-ээс 31/IX-ийг хүртэл явагдах бөгөөд 2 дахь жилд нийтдээ 5 сар ажиллах юм.

Уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулах горимын үзүүлэлтүүдийг уурхайн

ажиллах хугацаа болон хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтуудыг үндэслэн тооцоолж дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 3. Уурхайн ажиллах горим, хүчин чадлын үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	1-р жил	2-р жил
1	Жилийн хуанлийн хоног	хоног	365	365
2	Сул зогсолтын хоног	хоног	212	212
3	Уурхайн хуанлийн ажиллах хоног	хоног	153	153
4	Баяр ёслолын амралт	хоног	-	-
5	Цаг агаарын саатал	хоног	5	5
6	Жилд ажиллах хоног	хоног	148	148
7	Хоногт ажиллах ээлжийн тоо	ээлж	2	2
8	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12	12
9	Ээлжин дэх сул зогсолт	цаг	1.5	1.5
10	Ээлжинд бүтээлтэй ажиллах цаг	цаг	10.5	10.5
11	Цаг ашиглалтын итгэлцүүр	-	0.88	0.88
12	Хоногт ажиллах цаг	цаг	21	21
13	Жилд ажиллах цаг	цаг	3108	3108
14	Уурхайн цагийн хүчин чадал	м3/цаг	38.61	38.68
15	Уурхайн ээлжийн хүчин чадал	м3/ээлж	405.41	406.18
16	Уурхайн хоногийн хүчин чадал	м3/хоног	810.81	812.36
17	Уурхайн жилийн хүчин чадал	мян.м3/жил	120.00	120.23

Уурхайн ажиллах горимд үндэслэн тооцоход ордыг ашиглах ил уурхайн олборлолтын цагийн хүчин чадал 38.6 м³/цаг, хоногийн хүчин чадал 810.8 м³/хоног, жилийн хүчин чадал 120'000.00 м³/жил байна.

1.5. Уулын ажлын төлөвлөгөө

Ашиглалтын нийт хугацаанд 94.07 мян.м³ хөрс хуулж, 15.29 мян.м³ элс олборлох ба хөрс хуулалтын итгэлцүүр 5.54 м³/м³ байна. 2025 оны 05 дугаар сараас уулын ажил эхэлнэ.

1.6. Уурхайн үндсэн техник, тоног-төхөөрөмжийн иж бүрдэл

Ил уурхайд ашиглах уулын ажлын үндсэн техник, тоног-төхөөрөмжүүдийг уурхайн жилийн хүчин чадал, ерөнхий үйл ажиллагааны бүтэц, тухайн төрлийн техник, тоног-төхөөрөмжүүдийн үнэ зэргийг үндэслэн сонголоо.


Үүнд:

- ✓ Шимт хөрс хуулалт
- ✓ Хөрс хуулалт
- ✓ Алт агуулсан элс олборлолт

Ил уурхайн хэлбэр хэмжээ, чулуулгийн технологийн шинж чанар зэргийг үндэслэн дараах үйл ажиллагааны бүтцийг хөрс хуулалт болон үндсэн хөрс хуулалт, алт агуулсан элс олборлолтын ажилд тохиромжтой гэж үзлээ.

Хүснэгт 4. Ил уурхайн техник, тоног-төхөөрөмжийн иж бүрдэл

№	Ажил	Технологийн ажиллагаанууд		
1	Шимт хөрс хуулалт	Ухаж түрэх	Ухаж ачих	Тээвэрлэх
		Бульдозер	Утгуурт ачигч	Автосамосвал
2	Хөрс хуулалт	Ухаж ачих	Тээвэрлэх	Овоолго
		Экскаватор	Автосамосвал	Бульдозер
2	Элс олборлолт	-	Ухаж ачих	Тээвэрлэх
		-	Экскаватор	Автосамосвал




Зураг 2. Ил уурхайн техник, тоног-төхөөрөмжүүдийн иж бүрдэл

1.7. Баяжуулах технологи

Алт агуулсан элсийг СБК-1.4 маркийн угаах төхөөрөмж буюу скрубберээр ангилж, -20 мм ангилалын бүтээгдэхүүнийг ГДШ маркийн хоригт цорго буюу гүн дүүргэлтийн шлюзээр баяжуулах ба гүйцээн баяжуулалтанд СКО-2 маркийн сэгсрэх ширээ ашиглана.

Эдгээр тоног төхөөрөмжүүд нь элс угаан баяжуулалтанд ашиглагдаж байгаа ба төсөл захиалагчийн саналын дагуу үргэлжлүүлэн ашиглахаар төлөвлөсөн болно.



Зураг 3. Ордын алт агуулсан элсийг угаан баяжуулах технологийн бүдүүвч

Баяжуулах хэсгийн ажиллах горим, хүчин чадал

Баяжуулах хэсэг нь элс олборлох ажлыг дагалдан улирлын чанартай явагдах бөгөөд эхний жилд 6-10-р сар хүртэл, 2 дахь жилд 5-9-р сар хүртэл жилд дунджаар 168 хоног ажиллана.

Хүснэгт 5. Баяжуулах хэсгийн ажиллах горим

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Ашиглалтын жилүүд	
			1-р жил	2-р жил
1	Жилийн хуанлийн хоног	хоног	365	365
2	Сул зогсолтын хоног	хоног	212	212
3	Баяжуулах хэсгийн ажиллах хоног	хоног	168	168
6	Бэлтгэл ажил	хоног	15	15
4	Баяр ёслолын амралт	хоног	-	-
5	Цаг агаарын саатал	хоног	5	5
7	Жилд ажиллах бодит хоног	хоног	148	148
8	Хоногт ажиллах ээлжийн тоо	ээлж	1	1
9	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12	12
10	Ээлжин дэх сул зогсолт	цаг	1.5	1.5
11	Ээлжинд бүтээлтэй ажиллах цаг	цаг	10.5	10.5
12	Цаг ашиглалтын итгэлцүүр	-	0.88	0.88
13	Хоногт ажиллах цаг	цаг	10.5	10.5
14	Жилд ажиллах цаг	цаг	1554	1554

Хүснэгт 6. Баяжуулах хэсгийн хүчин чадал

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Ашиглалтын жилүүд	
			1-р жил	2-р жил
1	Жилд угаах элсний хэмжээ	мян.м3/жил	120.00	120.23
2	Хоногийн хүчин чадал	м3/хоног	810.78	812.39
3	Ээлжийн хүчин чадал	м3/ээлж	810.78	812.39
4	Цагийн хүчин чадал	м3/цаг	77.22	77.37

Элс угаан баяжуулах технологийн усан хангамж

Тус ордын элс угаан баяжуулах усан хангамжийн хувьд хаягдлын сангаас 600 м-ийн зайтай Туул голоос цэвэр усны хэрэгцээг хангана.

Хаягдлын санд эргэлтийн усны систем ашиглан угаах төхөөрөмжийн хаягдалтай хамт хаягдсан усыг тунгааж эргүүлэн угаах төхөөрөмжүүдийг эргэлтийн усаар хангана.

Тухайн орон нутгийн цаг агаарын байдлаас шалтгаалан усан сангийн усанд ууршилт шүүрэлтээс болж алдагдал гардаг. Иймд уг алдагдлыг гадаад эх үүсвэрээс цэвэр усаар хангаж, нуурын түвшинг тогтмол барьж байх шаардлагатай. Элс угаан баяжуулахад шаардагдах усны хэмжээ тооцож үзэхэд 1 м3 элс угаахын тулд 2.8 м3 ус шаардагдахаар тооцоо гарсан.

Элс угаан баяжуулахад шаардлагатай усны 70%-ийг эргэлтийн усаар, 30%-ийг цэвэр усаар хангана.

Шлюзэн дээр тунасан баяжмалыг ээлжинд буюу 10 цагт 1 удаа, тодорхой комиссын бүрэлдэхүүнтэйгээр (харуулын хяналтанд) султган авна.

Угаах төхөөрөмжөөс баяжмал авах ажлыг шлюзны доороос дээш секц тус бүрийн трафаретийг сөхөж, хуримтлагдсан баяжмал бүхий элсийг тусгай зориулалтын малтуур хүрээр хутган авч тусгай зориулалтын торхонд хийж, резинийг устай торхонд маш нарийн нямбай угааж баяжмалтай торхнуудыг машинд ачиж гүйцээн баяжуулах цех рүү хүргэх буюу шлюзний дэвсгэрийг займчин зайлах замаар гар аргаар багасган баяжмалыг ялгаж авдаг.

Шлюзнээс султган авсан баяжмалыг харуулын хяналтан доор гүйцээн баяжуулах цехэд аваачиж, баяжуулах ширээ, төвөөс зугатах хүчний сепаратор, гар тэвшээр ялгаж, хар шлихийг соронздож, хатааж, үлээн алтыг гарган авна.

Алттай баяжмалыг гүйцээн баяжуулах цехэд хүлээн авч, угааж үлээсний дараагаар жинлэж, комиссын бүрэлдэхүүнтэй алт олборлолтын журналд тэмдэглэж, алттай савыг битүүмжлэн сейфэнд хадгална.

Ялгах цехэд 3 хүн ажиллах бөгөөд тусгай харуул хамгаалалттайгаар алтыг гүйцээн боловсруулах ажиллагааг явуулна. Ялгасан алтыг аналитик жин дээр дэнсэлж сейфэнд хадгална. Сейфийг 2-3 албан тушаалтан лацдаж битүүмжилнэ.

Элс угаан баяжуулах цехийн хаягдлын сан

Хаягдлын сангийн байгууламж нь далан, хаалт, хаягдлын сан, булинга дамжуулах хоолой, насосны станц зэргээс бүрдэнэ. Элс угаан баяжуулах цехийн хаягдлын сан доорх нөхцөл шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- ✓ Ашиглалтын үед болон хаалтын дараа тогтвортой байдлаа хадгалах
- ✓ Хаягдал усыг эргүүлж ашиглах боломж бүрдсэн байх
- ✓ Үерийн болзошгүй аюулаас хамгаалагдсан байх
- ✓ Хаягдал тээвэрлэх зардал хямд байх

Хаягдал тээвэрлэхтэй холбоотой хүрээлэн буй орчны сөрөг нөлөөлөл хамгийн бага байх зэрэг болно.

Баяжуулах цехийн хаягдал нь 20 мм-ээс дээш ширхэглэлтэй гааль, 20 мм-ээс доош ширхэглэлтэй эфель байна. Эдгээр хаягдлуудыг нийлүүлж олборлолт явуулсан ил уурхайн орон зайг дүүргэх замаар техникийн нөхөн сэргээлтэд ашиглана. Эфелээс гарсан усыг урьдчилан бэлтгэсэн тунаах нуураар тунааж цэвэршүүлээд эргэлтийн усаар ашиглана.

Элс угаалгыг гравитацийн аргаар явуулах тул хаягдал нь химийн хортой материал агуулахгүй. Гадаргад ил гарсны дараа гадаргын усны нөлөөгөөр рН-ийн тэнцвэр нь алдагдахгүй тул гадаргын болон гүний усны шинж чанарт сөргөөр нөлөөлөхгүй.

Усан сан: Туул голоос технологийн усны хэрэгцээг хангана. Усан сангийн далангийн байгууламжийг ус алдагдал бага байлгах зорилгоор зориулалтын нийлэг материалаар доторлож бэлддэг. Уурхайн усан сангийн бүтэц нь бидний төлөвлөж буйгаар 2 ширхэг тунаах нуур болон 1 ширхэг цэвэр усны нууртай байна.

Хүснэгт 7. Технологийн усан сангийн багтаамж

№	Нуурын эзэлхүүн, мян.м3		
	Тунаах нуур -1	Тунаах нуур -2	Цэвэр усны нуур
1	168.84	168.84	15.97
Нийт	353.66		

Далангийн хийц: Далангаар ус шүүрэлтийг багасгах зорилгоор шавар материалаар хийсэн хамгаалалтын бүрхүүл, мөн тусгай зориулалтын нийлэг материалаар хучих зэрэг арга хэмжээ авна. Далангийн өндөр 3 м байна. Усан сангийн усны түвшинг 2.5 м-т байлгах шаардлагатай. Усан сангийн далан 40 м урт 30 м өргөн байна.

1.8. Ус ашиглалт

“Туулын талбайн өмнөд хэсэг (ХШ-967-971) үүсмэл орд болон Бүрэг нэртэй алтны шороон ордыг ашиглах” төслийн үйл ажиллагааны үед ажилчдын унд ахуй, элс угаан баяжуулах, нөхөн сэргээлт, ногоон байгууламж болон зам талбайн тоосжилт дарах зориулалтаар ус ашиглана.

Унд ахуйн ус хэрэглээ

Уурхайн ашиглалтын үйл ажиллагааны үед хэрэглэх ажилчдын унд ахуйн ус хэрэглээг БОАЖС-ын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 12-р хавсралт дахь ус хэрэглээний норм (150.0 л/хоног/хүн) – оор тооцов.


Хүснэгт 8. Уурхайн ажилчдын унд ахуйн ус хэрэглээний тооцоо

Ашиглалтын жилүүд	Нийт ажилчдын тоо	1 хүний өдрийн ус хэрэглээний норм, л/хүн	Нэг хоногийн ус хэрэглээ, м³	Нэг жилд ажиллах хоног	Жилийн ус хэрэглээ, м³
1-р жил	48	150	7.2	168	1209.6
2-р жил	48	150	7.2	168	1209.6

Ашиглалтын хугацаанд унд, ахуйн зориулалтаар хэрэглэх нийт усны хэмжээ, м ³	2419.2
--	--------

Ажилчдын унд, ахуйн ус хэрэглээг нормоор тооцоход хоногт дунджаар 7.2 м³, жилд дунджаар 1209.6 м³, ашиглалтын 2 жилийн хугацаанд нийт 2419.2 м³ ус хэрэглэх тооцоо гарч байна. Энэхүү усны хэрэглээ 14 км зайд байрлах Төв аймгийн Заамар сумын төвийн худгаас авах ба багийн дарга Ж.Хандмаатай ус ашиглах гэрээ байгуулсан. Уг худга нь 1 л/с ундрагатай. (Гэрээ, худгийн паспортыг хавсаргав.)

Худгийн байршил: N48°17'36.3", E104°25'07.7"



Зураг 4. Худгийн байршил

Технологийн ус хэрэглээ

Баяжуулах үйлдвэрийн технологиос гарах хаягдал усыг өөрийн урсгалаар тунаах санд хуримтлуулна. Тунаах сангаас тунасан усыг цэвэр усны сан руу өөрийн урсгалаар урсган баяжуулах үйлдвэрт дахин эргүүлэн ашиглана. БОАЖС-ын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 2-р хавсралт дахь ус хэрэглээний нормын гравитацийн аргаар 1 м³ элс угаахад 4.0 м³ ус зарцуулна. Технологийн усны 70%-ийг дахин ашиглаж, 30%-ийг нөхөн сэлбэлтээр шүүрлийн уснаас хангана. Баяжуулах үйлдвэрлэлийн технологид шаардлагатай усны хэрэглээг ашиглалтын жил бүрээр тооцож, доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 9. Баяжуулах үйлдвэрийн усны хэрэглээ

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	1-р жил	2-р жил
1	Баяжуулах элс, м ³ /жил	мян.м ³	120.0	120.23
2	Гравитацийн аргаар 1 м ³ элс угаахад	м ³	4	4
3	Баяжуулах үйлдвэрт хэрэглэх нийт ус, м ³ /жил	мян.м ³	480.0	480.92
4	Технологийн усны эргүүлэн ашиглалт, %	%	70	70
	эргэлтийн ус, м ³ /жил	мян.м ³	336.6	336.6
5	Технологийн усны нөхөн сэлбэлтийн ашиглалт, %	%	30	30
6	нөхөн сэлбэлтийн ус, м ³ /жил	мян.м ³	143.4	144.28
6	Жилд ажиллах хугацаа, хоног	хоног	148	148
7	Технологид хэрэглэх цэвэр усны хоногийн хэрэглээ, м ³ /хон	мян.м ³	0.96	0.97

Дээрх хүснэгтээс харахад ашиглалтын 1 жилд баяжуулах үйлдвэрийн технологийн нийт усны хэрэглээ 480 мян.м³/жил бөгөөд үүний 70% буюу 336.6 мян.м³/жил усыг технологит эргүүлэн ашиглаж, 30% буюу 143.4 мян.м³/жил усыг технологит нөхөн сэлбэлтээр ашиглахаар байна. Технологийн хэрэглээний усыг Туул голоос хангахаар төлөвлөсөн.

Нөхөн сэргээлтийн усалгаа

Уурхайн олборлолт, үйл ажиллагааны улмаас 5.61 га талбай эвдрэлд өртөх нөхөн

сэргээлтийн ус хэрэглээг Байгаль орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 13-р хавсралтын дагуу тооцооло.

Хүснэгт 10. Нөхөн сэргээлтэд зарцуулах усны тооцоо

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	1-р жил	2-р жил	Нийт
1	Нөхөн сэргээх талбай	мян.м ²	29.1	27.0	5.61
2	1 м ² талбайд 4 л ус	л	4	4	-
3	Хоногт зарцуулах усны хэрэглээ	м ³	116.4	108.0	224.4
4	Усалгаа хийх хугацаа	хоног	51	51	102
5	Нийт усны хэрэглээ	мян.м ³	5.93	5.5	-

Төсөл хэрэгжих хугацаанд нийт 5.61 мян.м² талбайд нөхөн сэргээлт хийх бөгөөд эхний жилд хоногт 116.4 м³, 2 дахь жилд 108 м³ ус хэрэглэхээр байна.

Зам талбайн усалгаа

Алтны шороон орд ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгальд орчинд, агаарын чанарт учирч болзошгүй сөрөг нөлө өллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд замын гадаргуу болон уурхайн орчны тоосжилт их үүсдэг газруудыг усалгааны зориулалтын машинаар услахаар төлөвлөсөн байна. 1 м² талбайд 2 л (Байгаль орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 13-р хавсралтын Зүлэгжүүлэлт, зам талбайн усалгааны норм) ус зарцуулна.

Хүснэгт 11. Зам талбайг услах усны тооцоо

Ашиглалтын жилүүд	Усалгаа шаардлагатай замын талбай, м ²	Замын усалгааны норм, л/м ²	Нэг удаагийн усалгаанд шаардагдах ус, м ³	Жилд услах хоногийн тоо	Жилийн ус хэрэглээ, м ³
1-р жил	9630	2	19.26	77	1483.02
2-р жил	11080	2	22.16	77	1706.32
Нийт	20710.0	-	-	-	3189.34

Төсөл хэрэгжих хугацаанд нийт 20710.0 м² зам талбайн тоосжилтыг бууруулах зорилгоор эхний жилд 1483.02 м³, 2 дахь жилд 1706.32 м³ ус хэрэглэхээр байна.

Төслийн нийт ус хэрэглээ

Төслийн үйл ажиллагааны хүрээнд ашиглах нийт ус хэрэглээний тооцоог дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 12. Төслийн үйл ажиллагааны үед ашиглах усны тооцоо

Ус хэрэглээний төрлүүд	1-р жил, м ³		2-р жил, м ³	
	Хоногт	Жилд	Хоногт	Жилд
Унд, ахуй	7.2	1209.6	7.2	1209.6
Баяжуулах технологи	960	143400	970	144280
Нөхөн сэргээлтийн усалгаа	116.4	5936.4	108	5508
Зам талбайн усалгаа	19.26	1483.02	22.16	1706.32
Нийт	1102.86	152029.02	1107.36	152703.92

Баяжуулах технологи болон ногоон байгууламж, зам талбайн усалгаанд эхний жил 1077.51 м³/хон, 2 дахь жил 1090.59 м³/хон ус зарцуулах ба энэхүү усыг уурхайн олборлолтын явцад уурхайд орж ирэх шүүрлийн усаар болон гадаргын уснаас хангах бүрэн боломжтой.

Туул голоос авч ашиглаж болох усны хэмжээ

Туул гол нь 6 дугаар эрэмбийн гол юм. Туул голын урсцын 25 хувийг газрын доорх ус, 6 хувийг цас мөсний ус, 69 хувийг хавар, зун намрын хур борооны ус эзлэх ба Туул гол нь усны горимын хэв шинжээрээ хаврын шар усны болон зуны болон хур борооны үерийн горимтой голд хамаарна.

Голын урсцыг бүрдүүлэгч үндсэн хүчин зүйл нь зун намрын хур бороо учраас усны түвшин дулааны улиралд ихээхэн тогтворгүй байдаг. 4-р сарын сүүлч 5-р сарын эхээр хаврын шар усны үер ажиглагдах боловч үргэлжлэх хугацаа, урсцын хэмжээгээр хур борооныхоос бага байна. Хаврын шар усны үерийн дараа богино хугацаатайгаар зуны гачиг үе ажиглагдах ба 7-9-р сар хүртэл зун намрын хур борооны үер ажиглагдаж, гол элбэг устай байна.

Туул голын дунд хэсгээс 10 хүртэлх хувийг авч ашиглах боломжтой. (Г.Даваа, 2015) Төсөл хэрэгжих хөндлүүрт гадаргын усны нөөцийн ажиглалтын мэдээтэй харьцуулсан судалгаа, ус хурах талбайн дундаж өндрийн хамаарал, голын урсцыг тооцох аргачлал, эмпирик томъёог ашиглан олон жилийн дундаж урсацтай харьцуулан 75 хувийн хангамшилаар тооцоог хийлээ.

Хүснэгт 13. Туул голоос авч ашиглаж болох усны хэмжээ

Голын нэр	Ус хурах талбай	Олон жилийн дундаж урсцын норм		Гачиг үеийн 75%-ийн хангамшилтай урсац		Авч ашиглаж болох усны хэмжээ
		м3/с	мян.м3/жил	м3/с	мян.м3/жил	мян.м3/жил
Туул-Заамар	47850	22.2	321926.4	13.7	248572.8	14914.37

Туул голоос авч ашиглаж болох экологийн урсцын хэмжээ 14914.37 мян.м³/жил байна. Баяжуулах үйлдвэрийн технологит нөхөн сэлбэлтээр 143.4 мян.м³/жил ус ашиглахаар тооцоо гарч байна.

1.9. Цахилгаан хангамж, ашиглалт

“Дархан-Сэлэнгэ”-ийн төвийн шугамд холбогдсон 6/04 кВа-ийн 400 кВа чадал бүхий трансформатороос уурхайн дотоод хэрэглээг хангана.

1.10. Дулаан хангамж

Уурхайн нь улирлын чанартай буюу дулааны улиралд үйл ажиллагаа явуулах учир халаалт шаардлагагүй байна. Ажилчдын амрах байр, оффисын байрыг халаах шаардлагатай тохиолдолд цахилгаан халаагуурыг ашиглаж байна.

1.11. Химийн бодисын хэрэглээ

Уурхайн олборлолт болон баяжуулах технологит химийн бодис ашиглагдахгүй.

1.12. Хог хаягдал

Уурхайн технологийн хаягдал, бохирдол

Хаягдал: Ордын нөөцийн хэмжээ, хөрс, элсний зузаан бага учир нөөцийг хаягдал багатай ашиглах боломжтой гэж үзсэн. Түрэх, ухаж ачих, тээвэрлэх үеийн технологийн хаягдлыг 1.0%-иар тооцсон ба ижил төрлийн ордуудтай харьцуулсан байна.

Бохирдол: Ордоос цул блоклог гантиг олборлоход бохирдол үүсэхгүй ба бутармаг гантигийг ухаж ачих үед хөрсний чулуулгаас дунджаар 3% бохирдохоор тооцсон байна.

Засварын газрын хог хаягдал:

Тус төслийн зүгээс Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолын хавсралт “Аюултай хог хаягдлын жагсаалт”-д заасан аюулын зэрэглэлээр шууд аюултай хог хаягдал гэж үзэх Ашиглалтаас гарсан машин, механизм, тэдгээрийг задлах болон засварлах үйл ажиллагаанаас үүсэх тосны шүүр, тоормосны шингэн, хар тугалгатай баттерей, аккумуляторын хаягдал үүсч байна. Бусад аюултай хог хаягдал нь хяналттай буюу аюултай хог хаягдалд хамруулах эсэхийг шинжилгээгээр тогтоох, аюултай шинж чанар үзүүлэгч бүрэлдэхүүнийг босго түвшинтэй тэнцүү болон түүнээс дээш хэмжээгээр агуулж байвал “аюултай” гэж үзэх хог хаягдлууд байна.

Хүснэгт 14. Төслийн үйл ажиллагаанаас гарах аюултай хог хаягдал

Хаягдал	Ангилал	Эх үүсвэр	Зохицуулалт	Тээвэрлэх, устгах
Хаягдмал аккумулятор	Аюултай	Засвар үйлчилгээнээс	Тусгай агуулахад хадгална.	Дахин боловсруулах үйлдвэрт өгнө.
Хөргүүрийн шингэн	Аюултай	Засвар үйлчилгээнээс	Тусгай хаягдлын талбайд хадгална	Дахин боловсруулах үйлдвэрт өгнө.
Техникийн ашигласан тос	Аюултай	Засвар үйлчилгээнээс	Тусгай хаягдлын талбайд хадгална	Дахин боловсруулах үйлдвэрт өгнө.
Тосны шүүр	Аюултай	Засвар үйлчилгээнээс	Шатамхай хаягдлын талбайд хадгална	Гэрээт байгууллагад хүргэж өгнө.

Тос түлшээр бохирдсон шингээгч материал	Аюултай	-	Шатамхай хаягдлын хогийн саванд хийнэ.	Гэрээт байгууллагад хүргэж өгнө.
Тос, тосолгооны материалын сав	Аюултай	Засвар үйлчилгээнээс	Тусгай хаягдлын талбайд хадгална	Гэрээт байгууллагад өгнө.
Шатах тослох материалаар бохирдсон хөрс	Аюултай	Тос, түлшний асгаралтуудаас	Бохирдсон хөрсний талбайд хүргэнэ.	Байгалийн аясаар дэгдсэний дараа хаягдал чулуулгийн овоолтын талбайд байршуулна.

Техникийн засварын хэрэглээнд ашигласан шатах тослох материалын хаягдал, дизелийн масло болон бусад тос, тосолгоо материал нь хаягдал болон гарна. Энэхүү хаягдлыг тусгай зориулалтын саванд түр хадгалан хуульд заасан хэмжээгээр “Хог хаягдал”-ын тухай хуулийн дагуу аюултай хог хаягдал зайлуулах, устгах, тээвэрлэх эрх бүхий аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан тогтмол хугацаанд зайлуулах хэрэгтэй.

Хийн хаягдал

Уурхайд ажиллах нийт машин техникийн олборлолтын явцад ашиглах дизелийн түлш, бензин нь химийн гаралтай хорт хийн хаягдал болж агаар орчныг бохирдуулна. Иймээс утаа ба хорт хийгээр агаарыг бохирдуулахгүйн тулд дизель хөдөлгүүрийн янданд шүүлтүүр тавьж өгсөн байх шаардлагатай.

Харин тослох материал нь химийн гаралтай шингэн хаягдал болон гарч хөрс бохирдуулагч эх үүсвэр болдог тул ийм төрлийн хаягдлыг өндөр температурт шатааж устгадаг технологийг ашиглан устгах, эсвэл ажилласан тосыг боловсруулдаг үйлдвэрт нийлүүлэхийг зөвлөж байна.

Хур бороо багатай дулааны улиралд, ялангуяа салхитай үед хөрс хуулах, зөөх, тээвэрлэх үйл ажиллагааны үед агаарт их хэмжээний тоос шороо дэгдэж, хүнд машин механизмын хөдөлгүүрээс утаа тортог, хорт бодис ихээр хаягддаг. Энэ нь агаар орчныг бохирдуулах, ажиллагсадын эрүүл мэнд болон орчны хөрс, ургамлын бүрхэвчид муугаар нөлөөлөх магадлалтай байна.

Ахуйн хог хаягдал:

Энгийн хог хаягдлын дийлэнх хувийг ахуйн хог хаягдал бүрдүүлнэ. Ажилчдын өдөр тутмын хэрэглээнээс гарах ахуйн гаралтай хог хаягдлууд болох хоол хүнсний үлдэгдэл, материалын сав баглаа боодол цаас, пластмасс, төмөр, шил, яс, мод зэрэг хог хаягдлууд байна. Төслийн талбайд хог хаягдлын төрөлд тохирсон түр хадгалах цэгүүд байдаг. Эдгээр цэгүүдэд хаягдал хуримтлагдсан үед зохицуулах зохих арга хэмжээг стандартын дагуу авч ажилладаг. Энгийн хог хаягдлын хувьд түр цэгт хуримтлуулан Бүрэгхангай сумын нэгдсэн хогийн цэгт хүргэдэг.

Дахин ашиглах хог хаягдлыг түр цэгт хуримтлуулан уурхайн дотоод хэрэгцээндээ ашигладаг. Дахин боловсруулах хог хаягдлыг түр цэгт хуримтлуулан гэрээт байгууллагууд руу хүргэх, гэрээт байгууллагуудаас зориулалтын машин уурхайд ирж авах зэргээр ажиллаж байна.

Уурхайн хэмжээнд нийт 48 ажилтан ажиллана. Иймээс уг тооцоог нэг ээлжинд ажиллах 24 хүнээр тооцоход, хоногт дунджаар 12 кг, сард 360 кг, жилд 1.8 тн, 2 жилийн хугацаанд 3.6 тн хатуу хог хаягдал гаргаж байна. Дээрх тооцоог 1 хүн өдөрт дунджаар 0.5 кг хатуу хог хаягдал гаргахаар хийв. Тус компани нь уурхайн тосгон дахь хатуу хог хаягдлаа зориулалтын багтаамж бүхий саванд хуримтлуулан Булган аймгийн Бүрэгхангай сумын захиргаатай хийсэн гэрээ, зөвлөмжийн дагуу сумын төвийн хог хаягдлын нэгдсэн цэгт зайлуулж байна.

Ахуйн шингэн хог хаягдал: Унд ахуйн үйл ажиллагаанаас шингэн хаягдал гарна. Унд

ахуйн үйл ажиллагаанаас ялгарах шингэн хаягдлын хэмжээг тооцохдоо нийт хэрэглээний 80 % гэж үзэв. Шингэн хаягдлын хэмжээ жилд 235.0 м³, нийт 2 жилийн хугацаанд 470.0 м³ ахуйн шингэн хаягдал гарах тооцоотой байна. Уг шингэн хаягдлыг бохирын цоонгт хуримтлуулаж байна.

Химийн бодисын хаягдал: Төслийн үйл ажиллагаанаас химийн хорт болон аюултай бодисын хаягдал үүсэхгүй.

1.13. Дэд бүтэц

“Туулын талбайн өмнөд хэсэг (ХШ-967-971) үүсмэл орд болон Бүрэг” нэртэй алтны шороон ордын уурхай нээж ашиглаж эхэлснээс одоог хүртэл хугацаанд буюу 2022-2023 онуудад уурхайд шаардлагатай барилга байгууламжуудыг барьж байгуулан ашиглаж байгаа бөгөөд эдгээр барилгууд нь сэндвич, карказ зэрэг байна.


Цаашдаа эдгээр барилга байгууламжуудыг үргэлжлүүлэн ашиглах бөгөөд холбогдох хуулийн дагуу элэгдлийг тооцон хуримтлуулж нэмэлт хөрөнгө оруулалтуудыг хийж явна.

Уурхайн бүрэлдэхүүнд:

- ✓ Алт агуулсан элс олборлох ил уурхай, шимт хөрсний түр овоолго
- ✓ Элс угаан баяжуулах хэсэг түүний дэргэдэх бүтээгдэхүүний овоолго
- ✓ Хаягдлын далангийн байгууламж
- ✓ Уурхайн ажилчдын хотхон
- ✓ Уурхай орчмын замууд зэрэг объектууд багтана.




Зураг 5. Ажилчдын байр



Зураг 6. Уурхайн оффис



Зураг 7. Гал тогоо



Зураг 8. Угаалгын газар

Уурхайн хотхоныг ордын баруун хойд хэсэгт 300 м зайд байгуулсан. Хотхон ажилчдын амьдрах байр болох гэр, сэндвичин захиргааны байр, ажилчдын цайны газрын байр болон угаалгын газраас бүрдэнэ.

Засвар, сэлбэгийн талбайг хотхоны баруун хойд хэсэгт 0.3 га талбайд байгуулсан. Талбайд сэлбэг, материалын агуулах, шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг байрлуулна. Засварын талбайн дэргэд түр шатахуун түгээгүүрийг байрлуулсан.

Сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмжийн түр агуулахыг 40 тн-ийн багтаамжтай контейнер суурилуулан ашиглаж байна. Жижиг эд анги хэрэгслийн хэмжээнээс хамаарч 2 ширхэг контейнер суурилуулсан. Энд гар ажиллагаатай 3-5 тн-ийн даацтай тельеферээр тоноглогдсон байна.

2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Цаг уур, уур амьсгал

Улирлын уур амьсгалын нөхцлөөр хавар намар, өвөл зуны үргэлжлэх хугацаа хосоороо ойролцоо байгаа нь эх гэзрын уур амьсгалын хахир ширүүн шинжийг илтгэж байна. Жилийн улирлын хугацаа нь тухайн үеийн цаг агаар бүрэлдэн бий болох онцлогоос хамааран зохих хэлбэлзэлтэй байх боловч жилээс жилд 5-7 хоногоос илүү хэлбэлзэхгүй.

Ашиглалтын талбай орчмын орд ашиглах газрын орчимд уур амьсгал бүрдүүлэгч үндсэн хүчин зүйлийн нэг нарны цацраг, нарны гийгүүлэх үргэлжлэх хугацаа нь орон нутгийн онцлогтой боловч бүсийн горимыг дагадаг. Жилдээ хэвтээ гадарга дээр 2850 мДж/м² шулуун цацраг, 4900 мДж/м² орчим нийлбэр цацраг ирж, нарны өндөр хамгийн бага байх өвлийн сар өдрүүдэд бага (нийлбэр цацраг 12 дугаар сард 150 мДж/м²) байснаа алгуур нэмэгдэж 5-6 дугаар сард нийлбэр цацраг 560-690 мДж/м² болтлоо өсч улмаар үүлшил, нарны өндөртэй уялдан буурч намар өвлийн горимд шилжиж байдаг нь аливаа аж ахуйн ажлын онцлог, голчлон гадаа хээрийн ажил хөдөлмрийн гол нөлөө ялгааны нэг үндэс болж өгдөг. Нарны цацрагийн тэнцэл 11 –ээс 2 дугаар сарын дунд хүртэл алдагдал ихтэй сөрөг утгатай байдгаас газар шороо өнгөнөөсөө гүнрүүгээ хөлдөлт үргэлжилж байдаг.

Салхины өөр нэгэн онцлог шинж бол салхигүй нам гүм байх давтагдал юм. Энэ онцлог талбай орчимд жилийн аль ч улиралд ойролцоогоор YII сард 32.0% , I, X сард 23-36% болж IY сард салхи ихтэйгээс бага шиг буурч 23.0% байгаа нь хонхор, хотгор нутгийг бодвол голын хөндий учир салхирхаг нутагт тооцогдоно. Энэ нь салхины хурдаар ч тодорч байна. Салхины чиглэлийн дундаж хурд зонхилох чиглэлүүдийнх бусад зүгүүдээс их байдаг. Тухайлбал зүүн өмнөөс-зүүн хойд чиглэлийнх бусад чиглэлүүдээс давамгайлж хавар, намрын саруудад бүр дахин нэмэгддэг. Эдгээр чиглэлийн дундаж хурд 2.6-7.4м/с болж, мөн зүүн, баруун зүгүүдийнх 0.0-3.0м/с хүрч бусад зүгүүдийнх 2.9-6.2м/с байна. Салхины жилийн дундаж хурд 2.8 м/с, харин намар салхи ихэсдэг. IY-Y сард 5.4-7.4м/с, өвлийн салхи багатай XII-II сард 1.0-1.3м/с бусад саруудынх 1.3-2.8м/с байгаа нь манай орны салхи багатай биш нутаг, говь цөлөөс эрс бага байдаг. Салхины хурдны 2 их (хавар, намар), 2 бага (өвөл, зуны) утгуудтай зүй тогтол хадгалагдаж байна. Салхины хамгийн их хурд бараг сар бүхэнд 10-15м/с, харин хаврын саруудад 14-24 м/с хүрнэ. Жилийн 23-50 гаруй хоногт 10м/с –ээс их салхитай, хүчтэй салхины хурд 16м/с давж байдаг. Машин техник, ер нь эгц босоо гадаргад салхи 35кг/м² (0.4 гПа) ачаа үйлчлэл үзүүлж ажил саатаж болох байна. 20 жилд тохиолдох тооцооны их хурд газар орчинд 28м/с, 100м –т 39м/с, 200м –т 43м/с тус тус хүрэх боломжтой. Бас жилдээ 19-25 өдөр цасан шуурга, 23 өдөрт шороон шуурга шуурч байгаагийн ихэнх нь 3-5 сард байна. Ийм учраас салхины ба ялангуяа хаврын саруудад газар шорооны ажлын үед их хэмжээний тоос шороо гарч агаар орчинд нөлөөлж, ачих тээвэрлэх газар шорооны ажлын нөлөөгөөр орчиндоо салхины чиглэл, хурднаас хамаарч багагүй тоос, шорооны бохирдолт болох магадлалтай байна.

2.2. Гадаргын ус

Судалгааны талбайн баруун талаар урсах Туул гол түүний томоохон цутгалан Хар бухын гол, Нарийн гол, жижиг салаанууд болох Ар наймган, Хайлааст, Бичигт хошууны гол болон Цайдам, Хүйтэн, Их цагаан зэрэг нуурууд, жижиг булгууд гадаргуугийн усан сүлжээг бүрэлдүүлдэг. Тус бүс нутагт хамгийн анх гидрогеологийн судалгааг 1979-1981 онд Дарханы ГХЭ-ийн Заамарын анги Туул голын хөндийн доод хэсэгт 1:50000-ын эрэл-зураглалын ажил явуулж /Д. Жамцаа, В. Довжид, Д.Лхагвасүрэн 1981 он/ Туул голын дэнж түүний баруун цутгал Урт-Сайр, Баянбулаг, Цагаанбулаг, Улаан эрэг, Хайлаастын амуудад алтны өндөр

агуулга бүхий голын хурдас илрүүлэн, талбайн хэмжээнд уст цэгүүдийн бүртгэл, ус агуулагч хурдас давхаргуудыг ангилан ялгажээ. Энэ бүс нутагт орших шороон ордын гидрогеологийн судалгааны ажил 1982 оноос эхлэн эрчимтэй хийгдэж иржээ. 1980-аад оны сүүлээс Туул голын баруун цутгалан Баянголын адаг орчимд Туул голд гидрометрийн пост ажиллуулж Туул голын урсацын жилийн хэлбэлзэл, усны чанарын судалгааг явуулж Хайлааст, Баянгол, Туулын дэнжийн хэсэг, Тосон, Цагаан булаг зэрэг олон орд газрын ордын гидрогеологийн судалгаа хийж, шавхалт түршилтын ажлууд хийгдэж газрын доорх усны үндсэн параметруудийг тогтоожээ. /ДГХЭ-ийн Туулын 3-р анги, Ш.Баярсайхан, Д.Жаргалан, Бубеников.В.Г. 1986-1988; 1989-1992 он/. Хайлаастын ордыг ашиглах, уурхайн тосгон байгуулах түүний ус хангамжийн судалгааг хуучин нэрээр ЗХУ-ын ПНИИИС гидрогеологи, инженер геологийн судалгааг явуулж Цагаан булгийн эхэнд тосгон байгуулах, түүний ус хангамжийн цооногуудыг ашиглалтанд оруулсан байна.

Туул голын ус хурах савын хэмжээнд 44013 км² талбайд жилд 818.0 сая шоо м газрын доорхи усны нөөц баялагтай байж болох тооцоо гаргасан байдаг. Туулын ай савын хэмжээнд тархсан хурдас чулуулагийн нас, литологийн төрлийг нэгтгэж, тэдгээрийн нүх сүвшилт зонхилсон, эсвэл ан цавшилт зонхилсон байдлаар ангилж газрын доорхи усны судлагдсан түвшин хөдөлгөөний төрх зэрэг хүчин зүйлийг харгалзаг ай савын хэмжээнд ус агуулагч 10 бүрдэл, ус агуулагч ан цавлаг 5 бүсийг ялгаж газрын доорхи усны 1 км² талбайд байж болох нөөц баялагаар нь 7 төрөлд хуваасан байдаг.

Туул голын хөндий нь өндөр өргөгдсөн, уулсаар хүрээлэгдсэн, эрс тэс уур амьсгалтай, хүйтний улирал урттай байдаг онцлогтой. Зуны улиралд эх газрын дулаан хуурай нөхцөлтэй байдаг тул хур тундас нь аадар шинжтэй ордог өвөрмөц нутаг гэж үздэг. Жилд унах хур тундасны олон жилийн дундаж хэмжээ 258.1 мм байх бөгөөд үүний 48.4% нь нийлбэр ууршилт, үлдэх 51.6% нь гадаргын болон газрын доорх усны тэжээгдэл болдог гэсэн судалгааг Туул голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн баг хийсэн байдаг. Туул гол, Тосонгийн голын орчим орсон аадар борооны эрчим, хур тундасны хэмжээний тухай тодорхой мэдээлэл байхгүй ойролцоогоор 40-50 мм орчим байдаг гэж үздэг. /2016 он “Шижир алт” тосгоны орчим/ Энэхүү ай савд Туулын, Урд Туулын гэсэн 2 томоохон региональ хагарал байдгийг судлаачид тогтоосон байдаг. Уг ай савыг хүрээлэн байгаа уулс нь газрын доорхи усны тэжээлийн бүс, хотгор хуримтлал нь зөөгдөл хөлийн бүс болдог. Уулс хоорондын артезын ай савын хэмжээнд палеозой, доод цэрд, неоген, дөрөвдөгчийн хурдасны устай бүрдлүүд, устай тектоникийн ан цавын бүс тус тус тархсан байна.


Туул голын хөндийн өргөн нь 100 м-ээс километр илүү, хөндийн хөндлөн огтлолын хэлбэр нь тэвш маягтай, хоёр тал нь ижил бус бөгөөд хажуунаасаа уулсаар шахагдсан байдаг. Гольдролын өргөн нь 40-60 м, гүн нь харгиан дээрээ 0.4-0.5 м, бусад газраа 2 м түүнээс илүү гүнтэй, ихээхэн тахиралдсан салаа, булан тохой, хар ус ихтэй. Эрэг нь намхан 0.6-1.5 м, тасархай, зарим газраа тэгширсэн, голдуу элсэнцэр-шавраас тогтоно.

Голын усны түвшин нь хур тунадсын хэмжээнээс шууд хамаарч 1.2-1.3 м хэлбэлзэнэ. Өвөлдөө зарим газраа тэс хөлддөг, зундаа үертэй үед 205 м³/сек хүртэл ус өнгөрөөдөг, урсгалын хурд нь 1.2 м/сек хүрнэ. Гольдролын налуужилт нь 0.001. Голын ус нь цэнгэг /0.2-0.4 г/л/, гидрокарбонат-сульфат-натрийн найрлагатай.

2.3. Хөрсний төлөв байдал

Төслийн талбай нь хөрс газарзүйн мужлалаар Хар хүрэн, хүрэн хөрсний дэд бүсийн Орхон – Шаамарын тойрогт (МУ-ын Үндэсний Атлас, 2009) хамаарах бөгөөд тухайн орчимд Монгол орны хөрсний ангилалаар Уулын хээрийн, Голын татмын, Хээрийн ба Хуурай хээрийн хөрсний төрөлд хамаарагдах Уулын хар хүрэн хөрс, Аллювийн нугын хөрс, Жинхэнэ

хүрэн хөрс тус тус тархсан байна. Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд жинхэнэ хүрэн хөрс тархсан бөгөөд хөрсний тархалтыг доорх зургаар харуулахын зэрэгцээ хүрэн хөрсний онцлогийг товч дурьдлаа.



Зураг 9. Төслийн талбайн орчны хөрсний тархалтын зураглал
Жинхэнэ хүрэн хөрс

Хүрэн хөрс нь Монгол орны хээрийн бүсийн бэлчээрийн үндсэн хөрс бөгөөд Монгол орны тал хээр, нам уулс, ухаа толгод, голын дэнж, нуур цөөрмийн ойролцоох хотгор, тэгшивтэр гадарга бүхий 1000-2100 (д.т.д) метр үнэмлэхүйн өндөрт голлон тархана. Түүнчлэн Хангайн нурууг тойрсон бэсрэг өвөр хажуу ба тэдгээрийн хоорондох талархаг хөндийд тархана.

Хөрсний дээд хэсэгт хүрэн өнгийн ялзмаг хуримтлалын давхаргатай үржил шим дунд зэрэг хөрсөнд тооцогдоно. Хүрэн хөрсний ялзмагт давхаргын зузаан 20 см-аас багагүй, ялзмагийн агууламж 0.16-0.20 хувь өнгөн хөрсний чулууны агууламж 10-40% байна. Хүрэн хөрсний ялзмагт болон карбонат хуримтлалын давхарга тод илэрдэг онцлогтой. Хар хүрэн хөрстэй төстэй боловч ялзмагийн хуримтлал арай бага байна.

Хөрсний гадаргын ба үе давхаргын морфологи шинж чанар

Судалгааны талбай нь үүсмэл орд бөгөөд 43.1 га талбай нь бүхэлдээ нөлөөлөлд өртөж байгалийн хэв шинжээрээ байгаа газар байхгүй байна. Иймээс хэв шинжээрээ ижил төстэй байж болох нөлөөлөлд өртөөгүй төлөөлөл болхуйц 2 байршилд хөрсний үндсэн зүсэлт, ухалт, морфологи бичиглэл хийж, хими, физикийн лабораторийн шинжилгээнд зориулан 3 ширхэг дээжлэлт хийв. Хөрсөн бүрхэвчийн төлөв байдлын онцлог, гадаргын төрх байдал зэргийг харгалзан Хөрсний хими болон физик шинжийн задлан шинжилгээгээр химийн үндсэн шинжүүдээс хөрсний ялзмагийн хэмжээ, урвалын орчин (pH), карбонат (CaCO_3), хөрсний цахилгаан дамжуулах чанар (EC), хөдөлгөөнт фосфор (P_2O_5), кали (K_2O)-ийн хэмжээ зэргийг тодорхойлсон. Харин хөрсний механик бүрэлдэхүүнийг ширхэгийн хэмжээний ангилалаар тодорхойлсон болно.

Хөрсний гадаргын болон үе давхаргын морфологи шинж чанар:



Зураг 10. Хөрсний зүсэлт-1

Байршил: Төслийн талбайгаас баруун урагш 2.1 км, Туул голын хойд хэсэгт байрлана.
Координат: N48°13'56.91" E104°18'59.89"

ДТД 964 м-т өргөгдсөн.

Хөрсний нэр: Жинхэнэ хүрэн хөрс

Хөрсний гадаргын байдал: Ургамлын нөмрөг талхлагдаагүй, гадаргатаа чулуу багатай, уурхайн олборлолтонд өртөөгүй эрүүл талбай.

Хөрсний үе давхарга: Хүрэн өнгөтэй (10YR 4/4), элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, нарийн ширхэгтэй хайрга 10 хувь орчим, үрлэн бүтэцтэй, ургамлын үндэс ихтэй байна. Давсны хүчилд буцлахгүй. Дараагийн үед шилжих шилжилт өнгөөрөө аажим.

Цайвар хүрэн өнгөтэй (10YR 5/4), элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, нарийн ширхэгтэй хайрга 15 хувь, бөөмөнцөр бүтэцтэй, давсны хүчилд буцлахгүй, ургамлын үндэс сийрэг, үе давхаргын шилжилт үндсээр болон өнгөөр аажим.

2.4. Ургамлан бүрхэвч

Ургамалжилт

Төслийн талбайн хээрийн судалгааны ургамлын бичиглэлүүд:

Ургамлын бичиглэл № 1. Лицензийн талбайгаас дээш 2 км-т зайтай газарт Туул голын хойт хэсэгт Ширэг улалж-дэрст бүлгэмдэлд бичиглэл үйлдэв. Бичиглэл хийсэн талбайн координат нь уртраг 104° 18'51.61", өргөрөг 48°11'53.57" д.т.д. 964 м.

Бүлгэмдлийн тусгаг бүрхэц 60% байх ба 1м² талбайд 5 зүйл ургамал тохиолдохоос үетнээс: Гялгар дэрс (*Achnatherum splendens*)– 30%, улалжнаас: Ширэг улалж- *Carex duriuscula* -10%, алаг өвснөөс-Агь- *Artemisia frigida* -5%, Адамсын шарилж- *Artemisia adamsii* -5%-ийн бүрхэцтэйгээр, 10 м² талбайд 11 зүйл ургана. Ургамал бүрхэвчгүй халцгай газар 40% байна. Ургамлын өндөр 3-25 см.

Хүснэгт 15. Ургамлын бичиглэл-1 (ургамалжилт)

Ургамлын латин нэр	Ургамлын монгол нэр	Бүрхэц,%	Өндөр,см
Өвслөг ургамал бүрхэвч		60	
<i>Achnatherum splendens</i>	Гялгар Дэрс	30	30-40
<i>Carex duriuscula</i>	Ширэг Улалж	10	6
<i>Artemisia adamsii</i> Bess.	Адамсын шарилж	5	5
<i>Artemisia frigida</i> Willd.	Агь	5	7
<i>Dracocephalum foetidum</i>	Үмхий Шимэлдэг	1	4
<i>Leymus chinensis</i> L	Түнхлэй Хиаг	0.5	15
<i>Urtica cannabina</i> L.	Олслиг Халгай	0.5	8
<i>Oxytropis filiformis</i>	Утсан Ортууз	0.5	3
<i>Potentilla bifurca</i>	Имт Г.	0.5	3
<i>Plantago depressa</i>	Навтгар тавансалаа	0.5	5
<i>Taraxacum officinale</i>	Эмийн Багваахай	0,5	6



Зураг 11. Ширэг улалж-дэрст бүлгэмдэл


Ургамлын бичиглэл №2. Хазаар өвс-хялганат бүлгэмдэл нь N48°13'53.17", E104°19'11.52", д.т.д 909 м, уулын хээр. Бүлгэмдлийн тусгаг бүрхэц 50% байх ба 1м² талбайд 6 зүйл ургамал тохиолдохоос зүйл ургамал тохиолдохоос үетнээс: Крыловын *krylovii* 25%, Дэрвээн хазаар өвс- *Cleistogenes squarrosa*-10%, улалжнаас: Ширэг улалж- *Carex duriuscula* - 5%, алаг өвснөөс: Агь Шарилж- *Artemisia frigida* -5%, Дагуур Хатны цэцэг- *Cymbaria dahurica*-2%- ийн бүрхэцтэйгээр, 10 м² талбайд 13 зүйл ургаж байна. Ургамлын өндөр 3-15 см.

Хүснэгт 16. Ургамлын бичиглэл-2 (ургамалжилт)

Ургамлын латин нэр	Ургамлын монгол нэр	Бүрхэц,%	Өндөр,см
Өвслөг ургамал бүрхэвч		50	
<i>Stipa Krylovii</i>	Крыловын Хялгана	25	15
<i>Cleistogenes squarrosa</i>	Дэрвээн Хазаар өвс	10	6
<i>Artemisia frigida</i> Willd.	Агь	5	3
<i>Carex duriuscula</i> C.A.Mey.	Ширэг Улалж	5	3
<i>Oxytropis filiformis</i>	Утсан Ортууз	2	3
<i>Cymbaria dahurica</i> L.	Дагуур Хатны цэцэг	2	4
<i>Koeleria macrantha</i> (Ldb.) Schend.	Том цэцэгт Дааган сүүл	0.5	5
<i>Agropyron cristatum</i> (L.) P.B.	Саман Хиаг, Ерхөг	0.5	10
<i>Haplophyllum dahuricum</i> (L.) G.Don.	Дагуур Хүж өвс	1	10
<i>Cymbaria dahurica</i> L.	Дагуур Хатны цэцэг	2	3
<i>Artemisia adamsii</i> Bess.	Адамсын шарилж	0.5	4
<i>A. dracunculus</i> L.	Ишгэн Ш.	0.5	6
<i>A. scoparia</i> Waldst et Kit.	Ямаан Ш.	0.5	5
<i>Taraxacum dissectum</i> (Ldb.) Ldb.	Цуулбар Б	0.5	5



Зураг 12. Хазаар өвс-Хялганат бүлгэмдэл



Зураг 13. Төслийн талбайн ургамлын хэв шинж

2.5. Бүрэгхангай сумын нийгэм эдийн засгийн судалгаа

Тус сум нь анх 1923 онд Богд Хан уулын аймгийн Шажин-Бүрэг уулын хошуу нэртэйгээр байгуулагдсан.

Улаанбаатар хотоос 265 км, Булган аймгийн төвөөс 86 км зайд оршдог. 349792 га газар нутагтай, үүнээс 282109 га нь бэлчээр, 10564 га нь хадлан 4361 га нь тариалангийн талбайд тооцогдож байна. Орхон ба Төв аймгийн Заамар сумтай хил залгаа оршдог. Тус сумын Бичигтийн голд Монголдоо томд тооцогдох хадны сүг зураг байдаг. Бүрэгийн нуруу, Дархан, Баянхангай, Шувуут, Их дулаан, Бага дулааны тахилгат хошуу 6 овоо, Шар хадны нуруу, Алтанга, Хутаг, Загзага, Эрдэнэ уул, Цоохор морьт зэрэг уулс, Орхон Туул зэрэг томоохон гол байдгаас гадна Ангирт, Шувуут, Бичигт, Хужирт, Хар бух гэх мэт 30 орчим гол горхи Булаг шанд, Дэлгэржаргалат, Ум, Хадат булгийн рашаанууд байдаг. Буга, бор гөрөөс, гахай, чоно, шилүүс, үнэг, дорго, туулай, тарвага зэрэг 20 гаруй ан амьтан мэрэгч байдаг. Хун, галуу, тогоруу, нугас, ангир, хөхөө, өвөөлж зэрэг нүүдлийн шувууд байдаг. Алтан гагнуур, бамбай, мэхээр, таван салаа, цээнэ зэрэг 20 гаруй төрлийн эмийн ургамлууд ургадаг. Дэд бүтэц, зам харилцаа сайн хөгжсөн. Улаанбаатар хот хүртэлх замын 205 км нь хатуу хучилттай. Эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон, үүрэн холбооны бүх сүлжээ орсон.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

“Гэрэлт шинэчлэл” ХХК-ийн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Туулын талбайн өмнөд хэсэг (хи-967-971) үүсмэл орд болон Бүрэг нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй хоёр эх үүсвэрийг авч үзэж байна. Үүнд:

- ✓ Элс олборлох процесс

ХӨРС ХУУЛАЛТ ► АЛТ АГУУЛСАН ЭЛСНИЙ ДАВХАРГА ОЛБОРЛОЛТ

- ✓ Алт үйлдвэрлэл

АЛТ АГУУЛАГЧ ЭЛСИЙГ УГААН БАЯЖУУЛАХ ► АЛТ ГҮЙЦЭЭН ЯЛГАН ХАДГАЛАХ ► БҮТЭЭГДЭХҮҮН БОРЛУУЛАХ (ТУШААХ)

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны төлөв байдал, дүгнэлт, өмнө хийгдсэн байгаль, нийгэм эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, газар дээр нь ажилласан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн “Магадлан жагсаах буюу хяналтын хуудасны арга” (checklist)-аар тодорхойлсон болно. Үнэлгээг дараах алхмуудаар гүйцэтгэв. Үүнд:

- ✓ Байгаль орчны үнэлгээний өмнөх үе шатуудад тодорхойлсон төслийн байгаль орчин, нийгмийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийн цар хүрээ, эрчим, хугацаа, шинж чанарыг нарийвчлан тодорхойлж, тоон ба чанарын шинжилгээ хийх.
- ✓ Болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүдийг төсөл хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний мэдээлэлд буулган судалж, сөрөг нөлөөллийн тархалт, үр дагаврыг үнэлэх.
- ✓ Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын хүрээнд төсөл хэрэгжих болон төслийн нөлөөлөлд өртөх нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгмийн өнөөгийн төлөв байдал, бохирдол, доройтлын түвшин тогтоох нэмэлт судалгаа, ажиглалт, хяналт шинжилгээний ажлыг гүйцэтгэх зэрэг орно.

Энэ арга нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн төрлийг жагсаан тэдгээрийг төсөлтэй холбоотойгоор харьцуулан тодорхойлсон хүснэгт бүрдүүлэх арга юм.

Болзошгүй нөлөөлөлд хамрагдах байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт, байгалийн нөөц ашиглалт, байгаль орчны өөрчлөлт, нийгэм- эдийн засаг, бусад гэсэн 5 үндсэн бүлэгт багцлан хувааж, магадлан жагсаах аргаар судлав. Нөлөөллийг сөрөг (-), эерэг (+), нөлөөлөлгүй (0) гэсэн 3 бүлэглэлээр үнэлж, эрчимжилтийг: “бага”, “дунд”, “хүчтэй” гэсэн 3 зэргээр тогтоож, хэлбэр, хугацаа, чиглэлээр нь үнэлсэн болно.

Хүснэгт 17. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

Байгаль орчны үзүүлэлт	Хэлбэр			Хугацаа			Нөлөө		Эрчим		
	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино	Дунд	Урт	Буцах	Буцалтгүй	Бага	Дунд	Хүчтэй
1. Байгалийн экосистемийн өөрчлөлт											
Газрын доорх усны урсац, горим, чанар өөрчлөгдөх	-					-		-			-
Уурхайн ухаш, хөрсний овоолго, зам болон барилга байгууламжаас ургамлын бүлгэмдэл, бүтцэд өөрчлөлт орох, талхлагдах	-					-		-			-
Уурхайн үйл ажиллагааны улмаас хөрсөн бүрхэвч элэгдэх, эвдрэлд орох, дарагдах, шимт байдал алдагдах	-					-		-			-
Уурхайн олборлолтын улмаас геологийн тогтоц өөрчлөгдөх	-					-		-			-
Хүнд машин механизм, техник, тоног төхөөрөмж, хүний үйл ажиллагаатай холбоотойгоор ойр	-				-			-			-

орчимд нутагладаг ан амьтдын амьдрах орон зай өөрчлөгдөх, хумигдах, үргэж дайчих											
Бичил уур амьсгалын өөрчлөлт		-		-			-			-	
2. Байгалийн нөөц ашглалт											
Газрын нөөц баялаг	-					-		-			-
Гүний усны нөөц	-					-	-		-		
Бэлчээрийн нөөц	-					-	-				-
Эрдэс түүхий эдийн нөөц	-					-		-			-
3. Байгаль орчны чанарын өөрчлөлт											
Шатах тослох материал, химийн бодисоор газар доор ус бохирдох		-		-			-			-	
Тоосжилт, автомашины яндангаас гарах утаа, үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт зэргээс агаар орчин бохирдох	-			-			-			-	
ШТМ-ын хэрэглээ, хог хаягдал хадгалалт, зайлуулалттай хобоотойгоор хөрс бохирдох	-				-		-				-
Уурхайн олборлолтын улмаас үүдэлтэй тоосжилтоос ургамлан бүрхэвч бохирдох	-				-			-			-
4. Байгалийн өнгө, төрх, түүх соёлын дурсгалт зүйл											
Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	-			-				-			-
Ландшафтын хэлбэр өөрчлөгдөх	-			-				-			-
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх	0			0			0		0		
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх	0			0			0		0		
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх	0			0			0		0		
5. Эдийн засаг, нийгмийн асуудал											
Улсад төлөх татвар, орлого нэмэгдэх	+				+			+		+	
Орон нутгийн орлого нэмэгдэх	+				+			+		+	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	+				+			+		+	
Ажлын байр нэмэгдэх	+				+			+		+	
Төслийн хэрэгцээг дагаад орон нутгийн үйлчилгээний байгууллагын эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+				+			+		+	
Хүний эрүүл мэндэд нөлөөлөх	-	-			-		-			-	
Нийт	20	3	0	5	9	8	7	15	2	8	12

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх шууд нөлөөлөл 20, шууд бус нөлөөлөл 3 байна. Нийт нөлөөллийн 2 нь бага эрчимтэй, 8 нь дунд эрчимтэй, 12 нь хүчтэй нөлөөлөлд хамрагдаж байна. Нийт нөлөөллийн 77.5% нь сөрөг, 22.5% нь эерэг байна. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нийт нөлөөлөл нь шууд, урт хугацааны, хүчтэй нөлөөлөл байна.

Төслийн үйл ажиллагааны үед уурхайн байршил, техник технологийн шийдэл болон төсөл хэрэгжих үеийн байгаль орчны асуудлыг тусад нь авч үзэн магадлан жагсаалтад түүний нөлөөллийн үр дагаврыг “бага”, “дунд”, “их” гэсэн утгуудын аль тохирохыг “+” гэж тэмдэглэв.

Хүснэгт 18. Төслийн байршилтай холбоотой болзошгүй нөлөөлөл

№	Технологийн шийдлүүд	Нөлөөлөл		
		Бага	Дунд	Их
Уурхайн процесс				
1	Хөрс хуулалт			+
2	Элс олборлолт			+
3	Баяжуулах			+
4	Алт ялгах		+	

Төсөл хэрэгжих тухайн нутаг дэвсгэр нь хүний нөлөө, байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг мэдрэмтгий, салхи ихтэй, ургамлан нөмрөг сайтай, төсөл хэрэгжиж буй талбай нь үүсмэл орд бөгөөд сул шороон хөрстэй тул тоосжилт үүсэх нөхцөлтэй. Орон нутгийн хэтийн хөгжилд сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулахгүй тул төсөл хэрэгжих орчинд байрлах Бүрэгхангай сумын иргэд болон бусад аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаатай зөрчилдөхгүй болно.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, БОННҮнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Мөн төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага, зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгасан байх шаардлагатай.

Төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг тухайн төслийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь үйл ажиллагааныхаа зардалд багтаан төлөвлөж зарцуулах.

Иймд “Гэрэлт шинэчлэл” ХХК нь байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах зорилгын хүрээнд 2025 оны БОМТөлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах зорилготой.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1. Ордын ашиглалтын үед сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 19. Ордын ашиглалтын үед сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

	Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг,стандарт аргачлал
1	АГААР ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ					
	Уурхайн олборлолт болон тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтын эх үүсвэрүүд: - Уурхайн олборлолтын үеийн хөрс хуулалт, олборлолт, овоолго хийх газар шорооны ажил, - Уурхайн үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хөдөлгөөн, тээвэрлэлтэнд явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох	Хөрс чулуулгийн овоолго, тээвэрлэлтийн зам зэрэг хөдөлгөөн ихтэй газруудад салхи ихтэй үед агаарт болон зам дагуу ус шүрших замаар тоосролтыг бууруулах арга хэмжээ авах.	Уурхайн ойр орчим	1931.5	Уурхайн үйл ажиллагааны үед, нөхөн сэргээлтийн үе шатуудад	Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003 /ЗГ-ын 2013 оны 327 дугаар тогтоолын хавсралт- Ус ашигласны төлбөрийн хувь хэмжээ/ /БО-ны сайдын 1995 оны 153 дугаар тушаалын хавсралт 4-“Зүлэг, талбай усалгааны түр норм
		Тээвэрлэлтэнд ашиглагдах автомашины бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавих, машины бүхээгт тоос нэвтрүүлэхгүй байх үүднээс жийргэвчийг цаг тухайн бүрт нь сольж байх.	Үйл ажиллагааны турш	ҮА зардал		Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003
		Тээврийн хэрэгслүүдэд Монгол Улсад мөрдөгдөж буй утааны ба бохирдлын стандартууд (MNS 5013:2003 бензин хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид, MNS 5014:2003 дизель хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид) болон Олон улсын холбогдох стандартуудын шаардлагын дагуу хяналт хийж, түүнд нийцүүлж ажиллах.	Үйл ажиллагааны турш	ҮА зардал		
		Гоожсон шатахуун түлшийг цэвэрлэх материалын нөөцтэй байх	Үйл ажиллагааны турш	150.0		
		Тоосжилт хэмжигч төхөөрөмж ашиглах	Үйл ажиллагааны турш	ҮА зардал		
	Нийт дүн			2081.5		
	Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг,стандарт аргачлал
2.ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ						
	Ордын ашиглалтын явцад хөрсний бүтэц найрлагад өөрчлөлт орох, хог хаягдал, тоосжилтоос бохирдол үүсгэх, хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх.	Шимт хөрс үүсгэх	Уурхайн хөрсний овоолго	900.0	Барьж байгуулах болон үйл ажиллагааны үе шатуудад	MNS 5914:2008- Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт.
		Уурхайн орчны замыг стандартын дагуу засч тэгшлэх, шаардлагатай тохиолдолд нэмж тэмдэгжүүлэх ажил хийх, олон салаа зам гаргахаас сэргийлэх	Үйл ажиллагааны турш	200.0		MNS 5915:2008- Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал
		ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах хадгалалтанд хяналт тавих, түгээгүүрийн хэсгийг	Үйл ажиллагааны турш	-		MNS 5916:2008- Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсийг хуулах, хадгалах техникийн

Шатах тослох материал, барилгын материалын хог хаягдал, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	хатуу хучилттай болгох				шаардлага MNS 5917:2008- Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага MNS 5918:2008- Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага. MNS 4915:2000- Ашигт малтмал эрж хайх явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага. MNS 4920:2000- Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага	
	Машин механизмын засвар үйлчилгээ хийх талбай, ШТМ-ын агуулах, хаягдал тос хадгалах цэг, ШТС зэргийн талбайг бетон хучилттай болгох	Үйл ажиллагааны турш	ҮА зардал			
	Хөрсний овоолгыг төлөвлөгөөний дагуу цэгцтэй хураах	Үйл ажиллагааны турш	-			
	Ажлын талбай ба туслах зам дагуу үүссэн хотос хонхор зэрэг хөрсний элэгдэл, эвдрэлийг их бага гэхгүйгээр тухай бүр нь дүүргэх, тэгшлэх арга хэмжээ авах, талбайн эмх цэгцтэй байдлыг хангаж ажиллах	Үйл ажиллагааны турш	ҮА зардал			
	Автомашин тос масло асгарч бохирдсон хөрсийг хуулан авч тусгаарлагч гадаргуу дээр овоолон 18-20%-ийн хлораминий уусмалаар бороожуулан ариутгаж, нефтийн бүтээгдэхүүний агуулга 0.07мг/кг-аас ихгүй, 4 этилт хар тугалганы хэмжээ 0.05 мг/кг-аас ихгүй нөхцөлд буцаан байршуулах	Үйл ажиллагааны турш	ШТМ хөрсөнд асгарсан тохиолдолд авч хэрэгжүүлэх ажил			
	Ахуйн гаралтай шингэн хаягдлыг шууд хөрсөнд шингэх байдлаар төлөвлөхгүй байх	Үйл ажиллагааны турш	350.0			
Нийт дүн				1450.0		
	Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг,стандарт аргачлал
3	УСНЫ НӨӨЦ, ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ					
Гүний усыг ашигласнаар усны нөөц хомсдох, усны бохирдол, шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох, газар доорх устай холбогдон ургадаг ургамалжилтанд сөргөөр нөлөөлж болзошгүй.	Усыг хэмнэлттэй ашиглах, ус ашигласны гэрээг хийж төлбөрийг төлөх	Үйл ажиллагааны турш	Туул голын сав газарт хамаарах ба 1 м³ гадаргын усны ЭЭЗ үнэлгээ 2651 төг байна. Үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглавал 0.9 коэффициентээр/ үйлдвэрлэлийн зориулалтаар хэрэглэх усны үнэлгээ нь 2385.9 төг/м³ болох юм.		Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль MNS 4288:1995 /ЗГ-ын 2013 оны 326 дүгээр тогтоолын хавсралт –Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/	
	Ус ашиглалтын гэрээ байгуулах, ус ашигласны төлбөр төлөх (зам талбайн усалгаанаас бусад ус зарцуулалт)	Үйл ажиллагааны турш	Ашигласан хэмжээгээр			
	Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн	Үйл ажиллагааны турш	-	-		

		хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөж ажиллах				
		Бохир усны хоолойг сайн чанарын хоолойг сонгож ашиглах, хяналт тавих	Үйл ажиллагааны турш	300.0	-	
		Болзошгүй эрсдлийн үед булингийг урсгах хамгаалалтын далан суваг шуудууг мэргэжлийн түвшинд байгуулах	Үйл ажиллагааны турш	ҮА зардал		
		Тунаах нуурны бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, хүнд металлын бохирдол MNS 4943:2015 стандартаар шинжлүүлэх	Үйл ажиллагааны турш	250:0		
	Нийт дүн			550.0		
	Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг,стандарт аргачлал
	УРГАМЛАН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ					
Уурхайн нөлөөллөөс болж ургамлан бүрхэвч доройтох, хомсдох, устаж үгүй болох цаашид бэлчээрийн доройтолд орох		Уурхайн зөвшөөрлийн талбай болон түүний ойр орчмын талбайн ашиглалтыг сайжруулах бэлчээр эдэлбэрийг хэвийн хадгалахад сум багийн удирдлагуудтай хамтран ажиллах.	Үйл ажилллагааны турш	Биологийн олон янз байдлыг хамгаалах ажлын зардалд орсон.		Ургамал хамгааллын тухай хууль
		Хөрсний нөхөн сэргээлт хийж дууссан талбайн хэсгүүдийг ургамалжуулахад зориулж үр суулгацыг туршиж бэлтгэсэн байх	Үйл ажилллагааны турш	550.0	Жил бүр	
		Хөрсний шинж чанар, хөрсний усны түвшинг харгалзан үзэж суулгац, олон наст ургамлын үр цацах замаар ургамалжуулна. Энд үр цацсан нөхцөлд хийсэхээс хамгаалах арга хэмжээг авсан байх	Үйл ажилллагааны турш	150.0	Жил бүр	
		Төслийн талбай болон талбайн орчмын ургамал хамгаалал, нөхөн сэргээлтэнд сөөг, сөөглөг ургамлыг ашиглах.	Үйл ажилллагааны турш	Нөхөн сэргээлтийн зардал	-	
	Дүн			700.0		
	Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг,стандарт аргачлал
	АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ					
	Хөрсөнд үүрлэдэг жижиг	Уурхайн эдэлбэрээс бусад эрүүл	Үйл ажилллагааны	-	-	Амьтны тухай хууль

хөхтөн амьтад, бусад шавж зэрэг амьд биетүүдийн амьдрах орчин алдагдах, сүйтгэгдэх Уурхайгаас үүдэлтэй тоосжилтоос болж уурхайн ойр орчмын амьдрах орчин доройтох	талбайд газар ухаж, амьтдын үүр нүх сүйтгэхгүй байх	турш			
	Тоосжилтыг дарах усалгааг зохих хуваарийн дагуу тогтмол гүйцэтгэх	Үйл ажилллагааны турш	-	-	
Хог хаягдлыг (хоолны) эмх замбараагүй хаяснаас болж зарим махчин амьтад идэх, амьтдын амьдрах орчин доройтох, бохирдох	Ахуйн хог хаягдлыг амьтад орж идэхээргүй саванд хадгалах, цаг тухай бүрт нь зайлуулах	Үйл ажилллагааны турш	-		
	Уурхайн кемп, засварын хэсэг, шаардлагатай газрыг ан амьтан орохоос хамгаалж хашаалах	Үйл ажилллагааны турш	270.0		
Дүн			270.0		
УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ					
Энэхүү тайлангийн сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны турш		-	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм, Галын аюулгүй ажиллагааны дүрэм ISO 14001:2004 Байгаль Орчны Удирдлагын Тогтолцоо	
Уурхай болон үйлдвэрт байгаль орчны асуудал хариуцсан мэргэжлийн 1 хүний орон тоог шинээр бий болгон ажиллах	2025 он				
Уурхайн ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулж, хамруулах	Үйл ажиллагааны турш		Жил бүр		
Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох дүүргийн байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	Үйл ажиллагааны турш		Жил бүр		
Ажиллагсдыг жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах.	48 хүн* 1100.0 =52800.0 ҮА зардал		Жил бүр		
Гал унтраах хэрэгслээр уурхайг бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах	Галын хор -110.0*15= 1650.0		Жил бүр		
Байгаль орчны хамгаалах тухай хуулийн 10 ¹ дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны аудитыг 2 жил тутамд хийлгэх	Гэрээгээр зохицуулагдана.		2 жилд нэг удаа		
Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдтэй харилцан тохиролцох					
Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 2 жил тутамд хийлгэх	Саналаар		Жил бүр		
Орон нутгийн иргэдийн өрхийн орлогыг дэмжих зорилгоор урт хугацаанд хэрэгжих боломжтой төсөл хөтөлбөрийг дэмжих, санхүүжүүлэх	Саналаар		Жил бүр		
Дүн			1650.0		
НИЙТ ДҮН			6701.5		

5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт 20. Нөхөн сэргээлтийн зардал

Ашиглалтын жил	Техникийн нөхөн сэргээлтийн ажил		Биологийн нөхөн сэргээлт		Зардал, мян.төг
	Талбайн хэмжээ, га	Ажлын хэмжээ, мян.м ³	Талбайн хэмжээ, га	Нэгж зардал, мян.төг	
1-р жил	2.91	216.0	2.91	1940.0	5645.4
Нийт	2.91	216.0	2.91		5645.4 ҮА зардал

Хүснэгт 21. Хаалтын нөхөн сэргээлт

№	Ажлын төрөл	Хэмжих нэгж	Нийт зардал, мян.төг
Техникийн нөхөн сэргээлтийн ажлын төрөл			
1	Нөхөн дүүргэсэн талбайг хэвгийжүүлэх	мян төг	15160.0
2	Нөхөн дүүргэсэн талбайг хэлбэржүүлэх	мян төг	2270.0
3	Хэлбэржүүлсэн талбайг шимт хөрсөөр хучих	мян төг	15620.0
4	Тунаах далан, ус цэвэршүүлэх даланг хэвгийжүүлэх	мян төг	5830.0
5	Тунаах далан, ус цэвэршүүлэх даланг хэлбэржүүлэх	мян төг	680.0
6	Тунаах далан, ус цэвэршүүлэх даланг шимт хөрсөөр хучих	мян төг	2960.0
7	Шимт хөрсний овоолго, зам, барилга байгууламжийн талбайг тэгшлэх	мян төг	1120.0
8	Шимт хөрсний овоолго, зам, барилга байгууламжийн талбайг шимт хөрсөөр хучих	мян төг	2960.0
	Нийт	мян төг	46610.0
Биологийн нөхөн сэргээлтийн ажлын төрөл			
1	Ил уурхайн шимт хөрсөөр хучсан талбайг ургамалжуулах	мян төг	6380.0
2	Тунаах, ус цэвэршүүлэх далангийн талбайг ургамалжуулах	мян төг	1910.0
3	Шимт хөрсний овоолго, зам, барилга байгууламжийн талбайг ургамалжуулах	мян төг	3130.0
	Нийт	мян төг	11420.0
	Нөхөн сэргээлтийн нийт зардал	мян төг	58030.0
	Төслийн хаалт, харуул хамгаалалтын зардал	мян төг	23970.0
	Цаашдын мониторинг хийх, орон нутагт үлдээх хөрөнгө	мян төг	11980.0
	Байгаль орчин хамгаалах болон уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн нийт зардал	мян төг	157500.0
	Жилд хуримтлуулах зардлын дүн	мян төг	78750.0

5.3. Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө

Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд орон нутгийн саналаар мод тарих бөгөөд өөрийн уурхайн ашиглалтын хугацаа 2 жил учир тарьсан модны арчилгааг хийхэд боломжгүй гэж үзээд орон нутагт мод тарих ажлыг төлөвлөж тооцоог гаргалаа.

Хүснэгт 22. 2025 онд тарих модны хэмжээ, зардал

№	Тариалах газрын байршил	Модны нэр	Тоо ширхэг	Зардал мян.төг
1	Буган аймгийн Бүрэгхангай сум (Орон нутгийн санал)	Бургас	1500	6750.0
		Улиас	3000	30000.0
		Яргай	1500	22500.0
		Шар хуайс	500	25000.0
		Хайлаас	4000	12000.0
		Өрөл	500	7500.0
		Монос	500	7500.0
		Долоогоно	500	7500.0
		Гацуур	1500	22500.0
		Нарс	500	6000.0
		Шинэс	1000	12000.0
			15000	130000.0 ҮА зардал

5.4. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг 3.1.11-д “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг ойлгоно гэж заасан байдаг. Ашигт малтмалын ашиглалтын нөлөөлөлд өртөж буй биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлага бий болсон тул биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээлт хийх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг дараах хүснэгтэнд тодорхойлсон болно.

Хүснэгт 23. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах боломжит газар	Хамгааллын арга хэмжээ	2025 он /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа
Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг	Орон нутгийн захиргааны байгууллага, иргэдийн төлөөллийг оролцуулан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх шаардлагатай газрын судалгаа гаргуулах.	-	2025 оны 2-р улиралд
	Нөлөөллийн бүсэд байгаа эвдэрч, эзэнгүй орхигдсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг үе шаттай хийх.	900.0	2025 оны 2,3-р улиралд
	Зэрлэг ан амьтдад биотехникийн арга хэмжээ авах.		2025 онд
	Булаг, шанд, гол горхи, уст цэгийг хамгаалах, сэргээх ажилд оролцох	800.0	2025 оны 2,3-р улиралд
Нийт		1700.0	

5.5. Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй тул 2025-2027 оны БОМТ-нд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

5.6. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

Төсөл хэрэгжих MV-021324 тоот талбайд археологи, палентлогийн хайгуулын судалгаа хийгдсэн.

Хүснэгт 24. Төслийн явцад хэрэгжүүлэх түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Нөлөөлөлд өртөх түүх соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Булган аймаг Бүрэгхангай сум	Түүх, соёлын өв дурсгалуудын талаарх мэдээлэлд анхааралтай хандах, сэргээх ажилд оролцох	Шаардлагатай тохиолдолд	500.0	Төслийн эхний шатанд	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
	Шаардлагатай тохиолдолд судалгааг дахин хийх тохиолдолд идэвхитэй оролцох	Санхүүжүүлэх	ҮАЗардалд	Тухай үед	-
	Нутгийн иргэдийн уламжлалт амьдралын хэв маяг, тахилга шүтлэгт хүндэтгэлтэй хандах, дэмжлэг үзүүлэх	Хандив өгөх	200.0	Тухай үед	-
НИЙТ ДҮН			700.0		

“Туулын талбайн өмнөд хэсгийн үүсмэл орд болон Бүрэг нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

5.7. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 25. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх, байгалийн гамшиг	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах Машин техникийн үйлчилгээ засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших	Нийт төсөл хэрэгжих талбай, барилга байгууламжинд	-	Өдөр бүр, тогтмол /уурхайн байгаль орчны мэргэжилтэн хариуцна/	Гамшгаас хамгаалах тухай хууль
	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэргэжлийн хүнээр сургалт хийлгэх	Уурхайн бүх ажилчдад	300.0	Сургалтыг 2 ээлжийн ажилчдад 1 удаа,	
	Гал гарсан тохиолдолд хэрэглэх галын иж бүрдлийг бэлэн байлгах, бүрэн бүтэн байдлыг хангах, хугацааг шалгаж байх, дууссан тохиолдолд сунгуулах	Уурхайн хэмжээнд ашиглагдах бүх галын иж бүрдэл	-		
	Аваар ослын үед авран хамгаалах төлөвлөгөөтэй байх	Үйл ажиллагааны турш	-		
	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох сумын байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	Үйл ажиллагааны турш	400.0		
	Уурхайн нийт ажилчдад ХАБЭА сургалт зохион байгуулж, уурхайн эрсдлийн менежментийн дагуу ажиллахыг зааварлах, дадлагажуулах	Жил бүр	-		MNS 4968:2000 MNS 6437:2014
	Уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй орон нутгийн иргэд, мал амьтан, уурхайн ажилчид болзошгүй аюулд өртөх эрсдэлд зарцуулах хуримтлал үүсгэх	Жил бүр эсвэл улиралд	500.0		
	Нийт		1200.0		

5.8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 26. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн Өртөг /мян.төг/	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Хатуу хог хаягдлыг ангилан ялгаж, зайлуулах, дахин ашиглах тогтолцоог нэвтрүүлэх	Үйл ажиллагааны турш	150.0	Жил бүр	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд БОАЖС, Сангийн сайд А-429/257
	Хатуу хог хаягдлыг цуглуулж нэгдсэн цэгт хүргэж устгаж байх	Үйл ажиллагааны турш	70.0		
	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, аль болох олон газарт байрлуулах	Үйл ажиллагааны турш	500.0		
	Хаягдал тос масло цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хийсэн гэрээний дагуу хаягдал тос маслыг нийлүүлэх	Үйл ажиллагааны турш	Хэрэглээний хэмжээгээр	Жил бүр	

	Тос маслоны хуванцар савыг нийлүүлэгчид эргүүлэн өгөх, дахин ШТМ хийлгэн авах	Үйл ажиллагааны турш	-	Ашиглалтаар	тушаалын хавсралт БОАЖС А/428 тушаал Хоог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам Хог хаягдлын тухай хуулийн 14-р зүйл
	Хаягдал тосыг хуримтлуулах сав байрлуулах	Үйл ажиллагааны турш	-		
	Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Үйл ажиллагааны турш	-		
	Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан цуглуулах цэгийг хашаажуулах, тэмдэг тэмдэглэгээ тавих	Үйл ажиллагааны турш	300		
	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулах	Үйл ажиллагааны турш	-	Жил бүр	
	А-429/257-р тушаалын хавсралтад заасан хаягдлыг дахин ашиглах боломжтой нийлүүлэгчид эргүүлэн өгөх, аль болох дахин ашиглах боломжтой нийлүүлэгчийг сонгон авах.	-			
	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ялганг ангилж бүртгэлжүүлэх	Үйл ажиллагааны турш	-	Жил бүр	
	Энгийн болон аюулгүй хог хаягдлыг ялган ангилж коджуулах	Үйл ажиллагааны турш	-	Жил бүр	
	Коджуулж ангилсан хаягдлыг харьяа сумын БО газарт бүртгүүлэх	Үйл ажиллагааны турш	-	Жил бүрийн 12-р сарын 20-ны дотор	
Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй	Шингэн хаягдлыг тусгай бодис хэрэглэн задлах	2025 оноос	410.0	Төслийн эхэн үед болон ашиглалтын үед	
Нийт			1430.0		

6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

“Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 3.1 дүгээр зүйл, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуульд зааснаар төслийг хэрэгжүүлэх явцад төслөөс байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдалд тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) гэнэ.

Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр нь “Туулын өмнөд хэсгийн үүсмэл орд болон Бүрэг нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах” төсөл хэрэгжиж буй бүс нутагт гарч болзошгүй өөрчлөлтүүдийг эрт тодорхойлох, сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны үр дүнг тайлагнах, авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа, хяналтын байгууллага, нутгийн оршин суугчдад байгаль орчин, амьдрах орчны өөрчлөлтийн талаар бодит мэдээлэл өгөх үндсэн зорилготой.

Төсөл хэрэгжүүлэгч нь үйл ажиллагааныхаа явцад байгаль орчинд учруулж буй нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтийг хянаж, байгаль орчныг хамгаалах ажлын үр дүнд тулгуурлан цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөх зорилгоор орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт тусгасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх мөн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад байгаль орчны төлөв байдалд өөрчлөлт орох, бохирдлын хэмжээ нь байгаль орчны стандарт, норм нормативаар тогтоосон хэмжээнээс хэтэрч илрэх тохиолдолд мэргэжлийн байгууллагад яаралтай хандаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Уг хяналт-шинжилгээний хөтөлбөрт төсөл хэрэгжих газрын агаар, усны чанар, хөрс, амьтан, ургамлын асуудлыг онцлон анхааран авч үзсэн бөгөөд байгаль орчны бохирдол, өөрчлөлтийг хянах гол үзүүлэлтүүд, хяналт шинжилгээ хийх давтамж, шинжлэх арга, дээж авах, хадгалах, тээвэрлэх шинжлэхэд баримтлах стандарт шаардлага зэргийг багтаасан болно. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол улсын хууль тогтоомж, стандарт, дүрэм, заавар арга зүйг баримтлах шаардлагатай.

Хүснэгт 27. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	БО-ны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал, мян.төг	Баримтлах стандарт, аргачлал	Дээд доод хязгаар
Агаарын чанар, бохирдлын мониторинг							
Тоос: PM2.5, PM10, Нийт тоос Утааны хий: Хүхэрлэг хий, Азотын давхар исэл, Угаарын хий	Төсөл хэрэгжих талбайд хяналтын 2 цэг сонгох зонхилох салхины доод ба дээд талд	Жилд 2 удаа	Уурхайлалт явагдаж буй талбайд	220.0	400.0	MNS 0017-2-5-12:1988 MNS ISO 4221: 2002 MNS0012-1-003:1982 MNS 0017-2-5-11:1988 MNS 4048:1988 ISO 16017-1:2000 ISO 16362-2:2003 MNS 5365:2004	24 цагийн дундаж: Нийт тоос-150 мкг/м³ PM2.5-50 мкг/м³ PM10-100 мкг/м³ SO₂-20 мкг/м³ NO₂-40 мкг/м³ CO-30000 мкг/м³
	Драгын талбай, хөрсний овоолго 2 цэг		Уурхай болон үйлдвэрийн үйл ажиллагаанаас орчинд тоосжилт үүсэх, тархах	100.0			
	Хүнд даацын машины тээврийн зам, баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн орчим		Машин механизмын ажиллагаа, хөдөлгөөнөөр шуугиан үүсэх	80.0		MNS-5919:2008 MNS ISO 4226:2000 MNS ISO 4227:2002 MNS 4585:2007 MNS 5885:2008	
Дүн /мян.төг/					400.0		
Усны нөөц, чанар, бохирдлын мониторинг							
Усны чанар pH, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Ундны ус авч хэрэглэж буй уст цэг	Үйл ажиллагааны үед жилд 2 удаа	Төслийн талбай орчим	150.0	300.0	MNS6148:2010 Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ	Газрын доорхи ус: pH-6.5 – 8.5 NH₄- 3.0 мгN/л NO₂ – 1 мг/л NO₃- 50 мг/л PO₄ – 3.5 мг/л Cl – 350 мг/л F – 1.5 мг/л SO₄-500 мг/л Mn-0.1 мг/л Ag-0.1 мг/л Fe-0.3 мг/л
	Технологийн усны хэрэглээний эх үүсвэр буюу гадаргын ус			150.0			
Дүн /мян.төг/					300.0		
Хөрсний чанар, бохирдлын мониторинг							
Хөрсний морфологи бичиглэл, pH, цахилгаан дамжуулалт, давс%, ялзмагийн агvvламж%, шим	Төслийн талбайд 4 цэг сонгох ШТМ түгээх цэгийн орчим болон олборлолтод өртөөгүй цэгт Угаан баяжvvлах	Жилд 2 удаа	Хөрсний элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	120.0	240.0	MNS 2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам; MNS 3298-1991 Шинжилгээний дээж авахад	Pb-100 мг/кг Cd-3 мг/кг As-6 мг/кг Cu-100 мг/кг Zn-300 мг/кг

тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд	үйлдвэрийн хашаанд Тунгаах нуурын орчим					тавигдах ерөнхий шаардлагууд; MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ; MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ	
Хүнд металлын агууламж	Дээрх 4 цэгт	Жилд 2 удаа	Түлш, тосолгооны материал болон химийн бодис, хог хаягдлаар хөрс бохирдох Угаан баяжуулах үйлдвэрийн хашаанд Тунгаах нуурын орчим	120.0			
Дүн /мян.төг/					240.0		
Нийт /мян.төг/					940.0		

6.1. БОМТ-ний хэрэгжилтийн талаар нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэгч “Гэрэлт шинэчлэл” ХХК жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг даргад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ. Төсөл хэрэгжүүлэгч нь нутаг дэвсгэрийн сум, багийн нийтийн иргэдийн хуралд БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийнэ.

Хүснэгт 28. БОМТ тайлагнах төлөвлөгөө

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацаа тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
